

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/125/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 01/54
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, хэрэгжүүлэх 18 арга хэмжээтэй баталснаас нийт 95,7 хувьтай дүгнэгдсэн байна. Тайлан хугацаанд байгууллагын нягтлан бодогч солигдсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	75,176,508.00	78,963,517.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,665.00	-
3121	Төгрөг	20,665.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	20,665.00	-
33	АВЛАГА	35,300,000.00	21,343,362.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	300,000.00	-
335	Бусад авлага	35,000,000.00	21,343,362.46
3351	Байгууллагаас авах авлага		1,585,362.46
3352	Хувь хүмүүсээс авах авлага	35,000,000.00	19,758,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,855,843.00	57,620,155.27
351	Түүхий эд материал	235,140.00	235,140.00
35110	Тусгай зориулалттай материал	235,140.00	235,140.00
354	Хангамжийн материал	39,620,703.00	57,385,015.27
35420	Аж ахуйн материал	35,548,203.00	43,556,815.27
35470	Бусад хангамжийн материал	4,072,500.00	13,828,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,524,919,447.85	4,746,651,742.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,524,919,447.85	4,746,651,742.97
392	Биет хөрөнгө	4,438,745,447.85	4,661,027,742.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,215,299.39	323,215,299.39
39202	Хуримтлагдсан элэгдэл	(211,026,378.11)	(232,768,229.63)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	416,497,338.00	416,497,338.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(135,256,823.49)	(180,498,147.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,429,328.60	131,282,563.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,097,511.27)	(75,202,717.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,139,426.68	107,888,811.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,210,875.68)	(64,107,271.18)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,378,984,143.00	1,476,665,109.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(59,372,928.25)	(82,355,997.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,085,267,224.50	4,567,364,475.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,473,822,795.52)	(1,726,953,490.36)
393	Биет бус хөрөнгө	86,174,000.00	85,624,000.00
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(1,150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	85,624,000.00	85,624,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,600,095,955.85	4,825,615,260.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,600,095,955.85	4,825,615,260.70
51	Засгийн газрын хувь оролцоо	4,600,095,955.85	4,825,615,260.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,451,938,176.48	1,451,938,176.48
51101	Өмч: - төрийн	1,451,938,176.48	1,451,938,176.48
512	Хуримтлагдсан үр дүн	2,973,157,019.60	3,198,788,350.93
51210	Өмнөх үеийн үр дүн	2,973,157,019.60	2,974,768,007.74
51220	Тайлант үеийн үр дүн	-	224,020,343.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	175,000,759.77	174,888,733.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,600,095,955.85	4,825,615,260.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,466,258,724.00	1,403,524,843.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	835,527,266.00	532,663,331.00
120	Нийтлэг татварын бус орлого	835,527,266.00	532,663,331.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	79,690,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	79,690,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	835,527,266.00	424,580,331.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	28,393,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	630,731,458.00	870,861,512.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,397,158.00	230,378,612.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,397,158.00	230,378,612.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	550,334,300.00	640,482,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	550,334,300.00	640,482,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	820,040,560.92	1,179,504,499.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,040,560.92	1,148,644,149.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,224,251.73	1,132,037,007.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,291,678.93	464,777,680.94
210101	Үндсэн цалин	176,333,151.70	387,494,392.23
210102	Нэмэгдэл	44,652,413.93	77,283,288.71
210104	Урамшуулал	11,306,113.30	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,224,510.75	56,482,338.05
210201	Тэтгэврийн даатгал	19,042,739.01	38,948,350.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,048,538.86	4,477,924.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,638,831.32	3,463,671.10
210204	Ажилгүйдлийн даатгал	408,581.88	867,387.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,085,819.68	8,725,004.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,775,776.47	53,093,061.95
210301	Гэрэл, цахилгаан	5,033,900.00	6,004,800.00
210302	Түлш, халаалт	35,611,876.47	46,958,261.95
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,743,760.00	55,506,802.73
210401	Бичиг хэрэг	2,180,250.00	3,699,765.00
210402	Тээвэр, шатахуун	23,144,660.00	20,408,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,608,000.00	2,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	29,810,850.00	22,757,700.00
210408	Бараа материал акталсны зардал	-	6,240,687.73
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	7,192,900.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	7,192,900.00
2107	Томилолт, зочны зардал	2,798,000.00	5,321,000.00
210702	Дотоод албан томилолт	2,798,000.00	5,321,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,175,349.66	18,761,885.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,255,354.66	18,041,885.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	419,995.00	420,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	397,715,175.92	469,901,338.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,983,808.00	53,966,330.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	275,731,367.92	415,935,008.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,816,309.19	16,607,142.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,083,900.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,083,900.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,732,409.19	16,607,142.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,051,059.19	6,824,285.78
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,681,350.00	9,782,856.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	30,860,350.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	30,860,350.00
222001	Тоног төхөөрөмж	-	9,960,350.00
223001	Бусад хөрөнгө	-	20,900,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	646,218,163.08	224,020,343.19
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	646,218,163.08	224,020,343.19

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	630,731,458.00	950,551,512.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		79,690,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		79,690,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		79,690,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	630,731,458.00	870,757,224.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,397,158.00	230,378,612.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,397,158.00	230,378,612.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	550,334,300.00	640,378,612.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	550,334,300.00	640,378,612.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	577,590,793.00	753,003,791.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	577,590,793.00	753,003,791.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,774,483.81	736,396,648.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,591,678.93	464,777,680.94
210101	Үндсэн цалин	176,633,151.70	387,494,392.23
210102	Нэмэгдэл	54,064,815.23	77,283,288.71
210104	Урамшуулал	1,893,712.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,224,510.75	57,767,700.51
210201	Тэтгэврийн даатгал	19,042,739.01	40,233,712.47
210202	Тэтгэмжийн даатгал	2,048,538.86	4,477,924.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,638,831.32	3,463,671.10
210204	Ажилгүйдлийн даатгал	408,581.88	867,387.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,085,819.68	8,725,004.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,775,776.47	53,093,061.95
210301	Гэрэл, цахилгаан	5,033,900.00	6,004,800.00
210302	Түлш, халаалт	35,611,876.47	46,958,261.95
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	130,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	41,187,350.00	44,787,365.00
210401	Бичиг хэрэг	2,180,250.00	3,824,665.00
210402	Тээвэр, шатахуун	10,336,100.00	13,661,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,671,000.00	2,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,000,000.00	24,901,700.00
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	9,300,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	9,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,798,000.00	5,321,000.00
210702	Дотоод албан томилолт	2,798,000.00	5,321,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,175,354.66	23,881,885.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,255,354.66	23,161,885.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	420,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,521,813.00	76,467,955.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	170,521,813.00	76,467,955.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,816,309.19	16,607,142.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,083,900.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,083,900.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,732,409.19	16,607,142.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,051,059.19	6,824,285.78
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,681,350.00	9,782,856.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	53,140,665.00	197,547,721.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	53,120,000.00	197,568,386.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53,120,000.00	197,568,386.00
2200	Дотоод эх үүсвэрээр	53,120,000.00	197,568,386.00
222001	Тоног төхөөрөмж	-	15,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	20,900,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	53,120,000.00	161,668,386.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(53,120,000.00)	(197,568,386.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,665.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,665.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,973,157,019.60	4,600,095,955.85
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,973,157,019.60	4,600,095,955.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,610,988.14	1,610,988.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,451,938,176.48	175,000,759.77	2,974,768,007.74	4,601,706,943.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(112,026.48)	-	(112,026.48)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	224,020,343.19	224,020,343.19
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,451,938,176.48	174,888,733.29	3,198,788,350.93	4,825,615,260.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,665.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	720,172,900.00	713,348,614.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,272,900.00	677,448,614.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	684,272,900.00	677,448,614.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,832,100.00	434,371,992.23
210101	Үндсэн цалин	387,954,500.00	387,494,392.23
210102	Нэмэгдэл	46,877,600.00	46,877,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ШИМТГЭЛ	54,354,000.00	53,894,815.04
210201	Тэтгэврийн даатгал	36,960,700.00	36,960,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,348,300.00	4,327,956.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,478,700.00	3,254,765.90
210204	Ажилгүйдлийн даатгал	869,700.00	837,393.72
210205	Эрүүл мэндийн даатгал	8,696,600.00	8,513,998.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,430,000.00	53,093,061.95
210301	Гэрэл, цахилгаан	6,004,800.00	6,004,800.00
210302	Түлш, халаалт	51,295,200.00	46,958,261.95
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,026,600.00	38,928,300.00
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,626,600.00	8,626,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,000,000.00	24,901,700.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,300,000.00	7,300,000.00
210604	Урсгал засвар	7,300,000.00	7,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,321,200.00	5,321,000.00
210702	Дотоод албан томилолт	5,321,200.00	5,321,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,420,000.00	22,956,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,500,000.00	22,236,070.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	620,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	420,000.00	420,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,589,000.00	60,583,375.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,589,000.00	60,583,375.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,900,000.00	35,900,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	35,900,000.00	35,900,000.00
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	15,000,000.00
223001	Бусад хөрөнгө	20,900,000.00	20,900,000.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	720,172,900.00	713,348,614.22
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	640,482,900.00	633,658,614.22
132001	Орон нутгийн төсвөөс	640,482,900.00	633,658,614.22
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	79,690,000.00	79,690,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	79,690,000.00	79,690,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,665.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.00	27.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,397,158.00	230,378,612.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,397,158.00	230,378,612.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,631,908.00	220,595,755.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		30,405,688.71
210102	Нэмэгдэл		30,405,688.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ШИМТГЭЛ		3,872,885.47
210201	Тэтгэврийн даатгал		3,273,012.47
210202	Тэтгэмжийн даатгал		149,968.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		208,905.20
210204	Ажилгүйдлийн даатгал		29,993.80
210205	Эрүүл мэндийн даатгал		211,006.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,833,650.00	5,838,400.00
210401	Бичиг хэрэг	1,004,250.00	804,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,766,400.00	5,034,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,000,000.00
210604	Урсгал засвар		2,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		99,906,781.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,798,258.00	78,572,000.00
21	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,765,250.00	9,782,856.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,083,900.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,083,900.00	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,681,350.00	9,782,856.82
213405	Нэмэлт санхүүжилт төвөлөрүүлэх шилжүүлэг	9,681,350.00	9,782,856.82
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	80,397,158.00	230,378,612.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,397,158.00	230,378,612.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,397,158.00	230,378,612.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь төрийн хуулийг дээдлэн хүндэтгэж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг тасралтгүй чанартай хүргэж, төр засгийн бодлого шийдвэрийн дагуу орон нутгаа хөгжүүлэх, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах, сурч боловсрох, эрүүл аж төрөх нөхцөлөөр хангах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын тогтвортой хөгжлийн өсөлтийг хангах зорилгоор улс, аймаг, сумын болон хувийн хэвшлийн төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар иргэдийн ажилтай орлоготой чанартай амьдрах орчин нөхцөлийг хангах бүхий л арга хэмжээг идэвхитэй явуулах
- Боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний хүрсэн түвшинг ахиулах
- Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх санг зориулалтын дагуу зарцуулж, иргэдийн оролцоо, хяналтыг ханган, сумын хэмжээнд бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг хөгжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, хэрэгжүүлэх 18 арга хэмжээтэй баталснаас нийт 95,7 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгж байхгүй ба Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Тамгын газрын даргын 2021 оны А/20 дугаар тушаалаар дотоод хяналт, шалгалтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу 7 чиглэлээр төлөвлөгөө гарган ажилласан байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газарт аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагад өдөр тутам мөрдөгддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 225,519.3 мянган төгрөгөөр буюу 4,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.7	-	(20.7)
Авлага	35,300.0	21,343.4	(13,956.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	39,855.8	57,620.2	17,764.3
Үндсэн хөрөнгө	4,524,919.4	4,746,651.7	221,732.3
Нийт хөрөнгө	4,600,096.0	4,825,615.3	225,519.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,600,096.0	4,825,615.3	225,519.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,600,096.0	4,825,615.3	225,519.3

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага данс эцсийн үлдэгдэл 21,343.4 мянган төгрөг болж буурсан нь "Ланд Овнер" ХХК-аар нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэх авлага 35.0 сая төгрөгийн авлага барагдсан боловч нийгмийн даатгалын авлага үүссэнээс шалтгаалсан байна. Бараа материал дансны хувьд аж ахуйн материал 8,008,612.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 9,755,700.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 5,853.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 12,749.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 419,410.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 37,788.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 1,300.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 14,920.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 35,000.0 мянган төгрөгийн бусад

үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 19,586.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 404,995.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,825,615.0 мянган төгрөг болж 225,519.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 481,688.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 158,794.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 640,483.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 640,483.0 мянган төгрөгт 1 удаа тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 720,172.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 713,348.6 мянган төгрөгийг зарцуулж 6,824.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 713,348.6 мянган төгрөг буюу 99,1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	581,091.70	574,867.04	6,224.66	98.9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	4,592.20	4,179.80	412.40	91.0
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад	35,900.00	35,900.00		100.0
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө	30,000.00	29,994.38	5.63	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам	12,790.00	12,790.00	-	100.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	17,799.00	17,799.00	-	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	38,000.00	37,818.40	181.60	99.5
	Дүн	720,172.90	713,348.61	6,824.29	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд мал тооллогын зардал 2,007.6 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэл 49,779.9 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 14,076.0 мянган төгрөг, зам засварын санхүүжилт 99,436.1 мянган төгрөг, суваг далангийн засварын санхүүжилт 63,966.7 мянган төгрөг, лавлагаа, цахим тендерийн орлого 797.3 мянган төгрөг, нийт 230,693.6 мянган төгрөгийн орлого орсноос цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 34,278.6 мянган төгрөг, хангамжийн бараа материал худалдан авахад 5,838.4 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 99,906.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 78,887.0 мянган төгрөг, нийт 220,910.8 мянган төгрөгийг зарцуулж, 9,782.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хөтөлбөр 95.7 %	720,172.9	713,348.6

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр урсгал зардал болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 494,156.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 494,156.9 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Харин зарим шууд худалдан авалтыг хийхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны 03/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Борнуур сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,466,258.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,993.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,495.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газар багуудын түлш халаалтын зардлыг хэмнэж 4,336.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 орлогын гүйлгээнээс 24 мэдээллийг мэдээлээгүй, зарлагын 8 мөнгөн гүйлгээнээс 2 гүйлгээг мэдээлээгүй, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 24 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цэсэд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 орлогын гүйлгээнээс 24 мэдээллийг мэдээлээгүй, зарлагын 8 мөнгөн гүйлгээнээс 2 гүйлгээг мэдээлээгүй, мэдээлбэл зохих 139 мэдээллээс 16 мэдээлэл хугацаа хоцроосон, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цэсэд мэдээлэх мэдээллийг зөвхөн нягтлан бодогч хариуцаж мэдээлэх биш тухайн мэдээллийг хариуцсан албан хаагчдад мэдээлэл оруулах эрхийг нээж өгч хариуцуулан ажиллах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын тамгын газарт 2023 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж, 5 албан шаардлага, 2 төлбөрийн акт тогтоосныг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 01/257 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	16,859.9	2	16,859.9	100%
Албан шаардлага	5	174,795.4	5	174,795.4	100%
Зөвлөмж	1	18,174.7	1	18,174.7	100%
Нийт дүн	8	209,840.1	8	209,840.1	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар урьдчилгаа, авлага, цалингийн өглөгийн бичилтүүдийг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа

Аудитаар нийт 198,781.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тайлант хугацаанд 38,413.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Авто замын засвар, үерийн далангийн засварын ажлыг сайжруулалтаар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 32,676.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 2 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Оны эцэст 1,585.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-д “Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Сумын засаг даргын Б/03, Б/06, Б/16 дугаар захирамжуудаар улс төрийн 6 албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл цалинд 10,622.3 мянган төгрөг олгосон зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөрөнгийн зардлын төсвөөс 20,468.4 мянган төгрөгийн урсгал зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвөөс хөрөнгийн шинжтэй зардлыг хөрөнгийн зардлын төсөвт суулгаж, зориулалтын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 25 -ны өдрийн дотор, хэрэгжилтийг 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу бодогдсон	1	38,413.0	1	38,413.0			1	38,413.0				
Үндсэн хөрөнгөнд сайжруулалт хийгээгүй	1	160,368.4			1	160,368.4	1	160,368.4				
Дүн	2	198,781.4	1	38,413.0	1	160,368.4	2	198,781.4				

